



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2018 оны 06 сарын 28 өдөр

Дугаар A/82

Улаанбаатар хот

Арилжаанд оролцох  
эрх олгох тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, "Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчтэй хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11 дэх заалт, "Үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.3.1 дэх заалт, "Ард секюритиз ҮЦК" ХХК-ийн 2018 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 18/86 дугаар албан хүсэлтийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Монголын хөрөнгийн биржийн гишүүн "Ард секюритиз ҮЦК" ХХК-ийн ажилтан /Д.Энхбилэг/-ны үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг 7 дугаар сарын 2-ноос 8 дугаар сарын 2-ны өдөр хүртэл хугацаанд түр түдгэлзүүлж, энэхүү хугацаанд тус компанийн ажилтан /Э.Хулан/-д үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгосугай.
2. Арилжаанд оролцох эрх авсан гишүүн ҮЦК-ийн ажилтанд Монгол улсын үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй хууль, тогтоомж, журам, зааврыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж, өндөр хариуцлага, ёс зүйтэй ажиллахыг үүрэг болгосугай.
3. Үнэт цаасны арилжааны программд нэвтрэх нэр, нууц үг олгох ажлыг Үйл ажиллагааны газрын Арилжааны алба /Д.Алдармаа/-нд, тушаалын биелэлтэд Хяналт тавьж ажиллахыг Хяналт, зохицуулалтын газрын Хяналт шинжилгээний алба /Д.Баттулга/-нд тус тус даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ X.АЛТАЙ



000291